



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 2 дугаар сарын 15-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн энгийн хувьцааг нэмж гаргах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалт, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн нэмж гаргах энгийн хувьцааны тоо ширхэг, нэгж үнийг компанийн 2022 оны санхүүгийн аудитлагдсан тайланд үндэслэн хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоож, саналаа Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 2 дугаар сарын 15-ны өдөр

№ 02


Улаанбаатар хот

Нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах эрх хэрэгжүүлэх эсэх тухай

Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.8 дахь заалт, Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 9/167 тоот албан бичиг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцааг эзэмшиж буй хувь хүн, хуулийн этгээдэд нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлсүгэй.
2. Нэмж гаргаж буй энгийн хувьцааны нэгж үнийг тогтоосны дараа хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацаа, журам зэргийг заасан мэдэгдлийг хувьцаа эзэмшигч бүрт хүргүүлэх ажлыг холбогдох хууль, "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР